

3. Ердийн ба нууц арга хэрэгсэл ашигладаг.
4. Тодорхой зорилго, баримталвал зохих зарчимтай.
5. Хэнийг, юуг эрж хайх нь тодорхой байдаг.
6. Эрэн сурвалжлах ажиллагааны төрөл тус бүр өөр хоорондоо ялгагдах өвөрмөц онцлог шинжүүдтэй.
7. Төрөл тус бүр нь өөрийн гэсэн өвөрмөц арга, зүй, тактикийн тусламжтайгаар хэрэгждэг ба практик хэрэгжилт нь тактик арга зүйгээ улам баяжуулан хөгжүүлдэг зүй тогтолтой.

* * *

Г.ЭРДЭМЭЭ



ХСИС-ийн
Удирдлагын
Сургуулийн
профессорын багийн
ахлагч, профессор,
хурандаа

ШОРОН (ХОРИХ ГАЗАР)-ИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Өнөөдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өөрийн "Хөгжлийн стратеги хөтөлбөр"⁶⁵-төө "ШШГБ-ын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцлийг олон улсын жишигт хүргэх" зорилт тавин ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилтоо хэрэгжүүлэхийн тулд дэлхийн улс орнууд дахь шорон (хорих газар)-гийн үүсэл хөгжил, хөгжлийн үе шатыг судлах зайлшгүй шаардлагатай тулгараад байна. Иймд гадаад улс орнуудад нэгэнт түгж хүлээн зөвшөөрөгдсөн ойлголтыг та бүхэндээ танилцуулахыг зорьлоо.

Дэлхий нийтийн нийтлэг ойлголтоор нийгэм зохион байгуулалтад орж төр бүрэлдэж эхэлсэн тэр үеэс л шоронгийн эхлэл тавигдаж эхэлсэн бөгөөд улс орны үүсэлтэй зэрэгцэн бичгийн хэл үүсч хөгжин, ингэснээрээ нийгмийн даган мөрдөх дэг журмыг заасан албан ёсны хууль эрхзүй бий болох үндэс тавигдсан билээ. Хамгийн эртнийх нь


⁶⁵ ХЗДХС-ын тушаал. 2009.07.15-ны өдрийн "Хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай" 156 дугаар тушаалаар батлагдсан. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр" нь 2008-2021 онд хэрэгжих бөгөөд тус заалт нь хөтөлбөрийн 5 дахь хэсэгт тусгагдсан

МЭӨ 1750-иад оны үед Вавилонд бичигдсэн Хаммурапийн Хууль⁶⁶ юм. Энэ хууль нь зөвхөн өшөө авахад тулгуурлаж байсан бөгөөд хохирогчид өөрсдөө өшөө авах маягаар бусдыг шийтгэж байв. Ийм төрлийн өшөө авах ял нь эртний Шумирын хууль, эртний Энэтхэгийн "Манугийн хууль"⁶⁷, эртний Египитийн "Гермес Трисмегист"⁶⁸ болон Мосэйн сургаал⁶⁹, Солонь хуулиуд гээд соёл иргэншлийн эхэн үеийн олон хууль цаазад байжээ.

Эртний төрт улсуудын суут сэтгэгчид ял шийтгэлийг энэрэнгүй байлгах талаар олон санал дэвшүүлж байсны нэг нь Платон болон Эртний Грекийн философичид шоронд хэрэгтнүүдийг дан ганц залхаан цээрлүүлэхийн оронд ялыг өөрчлөх саналуудыг дэвшүүлж байсан нь гайхалтай. Афинд харин хорих ялыг үүрэг хариуцлагаас зайлсхийсэн этгээдийг албадах хэрэгсэл болгож байсныг анх удаа торгуулиа төлж барагдуулж чадаагүй хүмүүст ашиглаж эхэлжээ. Тэд хоосрон торгуулиа төлж

чадахгүй болмогц тодорхойгүй хугацаагаар хорьдог байснаа сүүлдээ хугацаатай болж өөрчлөгджээ.

Эртний Афины шоронг "гинжит газар" (*desmoterion*)^{70 71} хэмээн нэрлэнэ. Шоронг зөвхөн хорихоос гадна яллах



Зураг 1: Мамертине шоронгийн зураглал

хэлбэр болгон анх ашигласан улс бол эртний Ромчууд юм. Төмөр тор, нийтийн байрны подваль, уурхай зэрэг байгууламжийг ашиглан хоригдлуудыг байрлуулж байсан бөгөөд МЭӨ 640-өөд оны орчим Анк Марций⁷² хааны төр барих үед байгуулагдсан Мамертине шорон нь тухайн үедээ хамгийн их танигдсан шорон байлаа. Энэхүү шорон нь эртний Ромын газар доорх

⁶⁶ Хамурап хааны төр барих үед гарсан (МЭӨ 1792-1750 он). Ж.Цэцэгмаа. Гадаад орнуудын төр эрх зүйн түүх. УБ.: "ADMON" хэвлэлийн газар, 2007 он. 104-113 дугаар тал ISBN 978-99929-0-378-3

⁶⁷ Энэхүү хуулийг ертөнцийн бүх хүмүүсийн өвөг гэж уламжлалт домог ёсоор үздэг Ману бичсэн гэдэг. Ж.Цэцэгмаа. Гадаад орнуудын төр эрх зүйн түүх. УБ.: "ADMON" хэвлэлийн газар, 2007 он. 114 дүгээр тал ISBN 978-99929-0-378-3

⁶⁸ -Манава-Дарма-шастра (*manu-smriti*; *Manava-dharma-shastra*) Эртний энэтхэгийн хамгийн нэр хүндтэй хуулийн эмхтгэл. Үүнийг домгийн анхны хүн хууль тогтоогч Ману-г зохиосон гэж үздэг. Одоогийн хэлбэр нь МЭӨ I зуунаас улбаатай. . Britannica Ширээний нэвтэрхий толь. NEPKO, 1926-р талд, ISBN 978-99962-66-20-10

⁶⁹ (грек. *μὴς ο Τρισεύστος*; латин. *Mercurius ter Maximus*) буюу Гурвантаах агуу Гермис.

⁷⁰ Мосэ (Moses) (МЭӨ XIV-XIII зуунд нэрд гарсан) Жүүдийн шашины эш үзүүлэгч. Britannica Ширээний нэвтэрхий толь. NEPKO, 2100 талд, ISBN 978-99962-66-20-10

⁷⁰ Афинчууд *δεσμητήριον* (хорих) (*δέω* — холбож уях гэсэн грек үгнээс үүдэлтэй) мөн (эвфемистически) *οἰκήμα* (оршин суух) буюу *ἀνακαίων* (албадан байршуулах) хэмээн нэрлэж байв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2014. №4 (12)-д

⁷¹ Tullianum хэсгийг харах Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2014. №4 (12)-д

⁷² (Anclus Marcius) Эртний Ромын 4 дэх хаан. МЭӨ 640-616 онд төр барьсан.

бохирын систем дотор байрлаж байсан бөгөөд тэнд маш том хорих хэсгийг бий болгож, хоригдлууд хүний ялгадасг бохирдон маш бохир муу нөхцөлд хоригддоно.

Зураг 1: Мамертине шоронгийн зураглал

1. Мужаан Санкт Иосефын Сүм
2. Ариун Загалмайн Чапел (шүтээний байр).
3. Carcere гэж нэрлэгдэх хэсэг
4. Tullianum гэж нэрлэгдэх хэсэг




Зураг 2: Мамертине шоронгийн өрөөний дотор тал

Мөн олон нийтийн ажилд хүчээр ажиллуулах ял нийтлэг байснаас гадна иргэдийг боолчлох, дуулгаваргүй боолуудыг тавцанд гинжлэн хүнд хөдөлмөр хийлгэх ялыг ихээр ашиглаж байв.

Дундад зууны⁷³ үед Европт шилтгээн, болон байрны подвалийг шорон болгон ашиглаж байсан ба иргэдийг хорих эрх нь эзэн хаанаас эхлээд бүсийн шүүх, хотын зөвлөл гээд бүх шатны эрх мэдэлтнүүдэд байсан учир нийгэмд эрх мэдэлтэй, засаг захиргааг барьж буй этгээдүүд иргэдийг

хорих эсвэл алахыг шийдвэрлэх эрхийг эдэлнэ. Түүнчлэн завин боолчлол буюу усан онгоц, завинд хүмүүсийг гинжлэн усан цэргийн болон худалдааны завинд сэлүүрчин хийлгэх ял нийтлэг хэвээр үйлчилж байлаа.



Зураг 3: 1818-1834 он хүртэл гэмт хэрэгтнүүдийг хориход ашиглаж байсан Дептфордод байрлах "Эйч Эм Эс ДисCOVERи" (HMS Discovery) нэртэй арал үүсгэн байрлуулсан гэмт хэрэгтнүүдийг хорих хөлөг онгоц.

Ял шийтгэлийн хэлбэрүүд нь цаазаар авах, зэрэмдэглэх (чихийг тасдах гэх мэт ил харагдах эрхтнийг тасдах), ташуурдах, болон тамгалах гэх мэт биеийг өвтгөх ялаас гадна дөнгөлөн олон нийтийн газар орхиж ичээх ял нийтлэг байсан байна. Дундад зуунаас XVI, XVII зуун хүртэл Европт хорих шийтгэлийг дангаар нь ял шийтгэл болгон ашигладаггүй зөвхөн шүүх хурал хүртэл болон шүүх хурлын дараа ял шийтгэлээ хүлээж буй хүмүүсийг түр байрлуулахад ашиглаж байснаараа онцлогтой.

Английн Лондон хотын Брайдуэл Хауз засан хүмүүжүүлэх төвд хөнгөн гэмтэй, орон гэргүй тэнүүлчид, сахилга батын зөрчил гаргасан нутгийн ядуусыг хорьдог байсан бөгөөд энд

⁷³ Европын түүхэнд Ромын эзэнт Улс-ын мөхлөөс Сэргэн мандалтын зуун-ы эхэн үе хүртэлх хугацаа. V зууны үед Баруун Ромын эзэнт Улсын хүн ам, эдийн засгийн чадавхи суларч, хотуудын хэмжээ болон тэргүүлэх байр суурь доройтож ирсэн. Үүнд III зуунд эхэлсэн ард түмнүүдийн их нүүдэл ихээр нөлөөлжээ.

тэдэнд ажил олгон, ажил хөдөлмөр эрхлэх замаар амьжиргаагаа хэрхэн залгуулахыг зааж байсан нь энэ үеийн хамгийн дэвшилтэт өөрчлөлт болсон ба XVII зууны сүүлчээр энэхүү аргыг хууль эрхзүйн хяналтан дор бусад шоронгуудад нэвтрүүлж эхэлсэн билээ.

1610-1770 аад оны үед Америк улс, 1788-1868 онуудад Австрали улс тухайн үедээ нэлээд олон хэрэгт тохоодог байсан цаазын ялын оронд Британийн эзэнт гүрэнд байрлах хорих колони хоригодох ялыг санал болгодог байсан ба гэмт хэрэгтнүүдийг хорих тусгай хөлөг онгоцоор тээвэрлэн хүргэдэг байжээ.

XVIII зууны эхээр Франц улс мөн гэмт хэрэгтнүүдийг Луизана зэрэг халуун орны хорих колони руу илгээдэг ба *Ole du Diable* буюу Четгөрийн арал хэмээн алдаршсан хорих колони 1951 он хүртэл Францын Гвианад ажиллаж байв. XVII зуунд Оросын Сибирь, Зүүн хязгаарт хүн ам цөөтэй, алслагдсан нутагт байгуулагдаж байсан Каторга шоронгууд нь маш хүнд хүчир хөдөлмөрийн хорих лагерь байсан бөгөөд тэдгээр нутагт хот суурин газар цөөтэй, хүнсний хангамж маш бага байсан нь Сибирь ял шийтгэлийн хамгийн аймшигтай нутаг болох нэрийг зүүсэн.

Гэмт хэрэгтэн болон өрөө төлж чадаагүй хэрэгтнүүдийг хоёуланг нь хорьдог шоронд эхэндээ эхнэр, хүүхдүүдээ авчрахыг зөвшөөрдөггүй байсан авч сүүлдээ зөвшөөрдөг болжээ. Учир нь шоронгийн хянагч нар хоол хүнс, уух юм, хууль ёсны үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хоригдлуудаас мөнгө нэхэмжилж орлого олдог байсан ба энэ систем бүхэлдээ хууль бус авлигад идэгдсэн байна.

XVII зууны үеийн шоронгийн нэг шинэчлэл бол Английн Лондон хотын Брайдсуэл гэх хүүхэд эмэгтэйчүүдийн засан хүмүүжүүлэх байр нь эмнэлгийн тусламж үзүүлдэг цорын ганц шорон байсан юм.

Хорих колониуд руу гэмт хэрэгтнүүдийг илгээх явдал XVIII зууны сүүл үеэс аажмаар хумигдаж оронд нь хуучин завийг түр зуурын хорих байр болгон ашиглах явдал түгээмэл болов. Хорих хөлөг онгоцнуудын нөхцөл байдал үнэхээр аймшигтай байсан ч бөөнөөр хорих болон хөдөлмөр хийлгэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон ял шийтгэлийн боломжтой хэлбэр болохыг хүмүүст ойлгуулсан хэлбэр болсон байна.

Удалгүй XIX зууны эхээр анхны зохион байгуулалттай шоронгийн шинэчлэлийн хөдөлгөөн эхэлсэн бөгөөд 1810-аад оны үеэс анхны шорон буюу засан хүмүүжүүлэх байгууламж бий болж энэ нь өнөөгийн бидний мэдэх орчин үеийн шоронгийн системийн эхлэл болон тавигджээ.

XVIII зууны үеэс эхлэн олон нийтийн дунд цаазаар авах, тарчлаан зовоох ял шийтгэл нь байнгын эсэргүүцэлтэй тулгарч энэ нь Европ, АНУ-д илүү түгэн дэлгэрчээ. Ялангуяа хулгай зэрэг бага гэмт хэргийн төлөө алах ял өгөх нь олон нийтийн зүгээс үзүүлэх эсэргүүцэлтэй маш их тулгарч байсан тул ихэнх шүүгчид гэмтнийг алах ялаар шийтгүүлнэ гэдгийг мэдэж байвал яллахаас татгалзаж байв. Иймээс эрх баригчид энэхүү асуудлыг хэрхэн шийдэх, ямар шийтгэл оноовол үүнтэй холбогдон эмх замбараагүй байдал үүсч, зэрлэг балмад зүйл нийгэмд гаргахгүй байх вэ? хэмээн бүхий арга замуудыг эрэлхийлж эхэлжээ. Эцсийн дүнд гэмтнүүдийг

олноор нь хорьж, хүнд хөдөлмөр эрхлүүлэх шийдэлд хүрсэн байна. Гэсэн хэдий ч тухайн үед үүссэн шоронгийн шинэчлэлийн асуудал хоёр эсрэг тэсрэг үзэл бодолтой тулгарчээ.

Эхнийх нь ташуурдах, дүүжлэх зэрэг ялыг шоронд хорих ялаар орлуулан тэнд хүнд хэцүү, сүрдмээр нөхцөл байдлыг бий болгон хүмүүс дахин шоронд орохгүйн тулд гэмт хэрэг үйлдэхгүй байх ёстой гэсэн үзэл санаа.

Хоёр дахь нь шашны үзэлд үндэслэн гэмт хэрэг үйлдэх явдлыг нүгэлтэй дүйцүүлэн хорих ялыг засан хүмүүжүүлэх, гэмт санаа бодлыг нь өөрчлөх зорилгоор ашиглан шоронд Христийн⁷⁴ ёсзүй, дуулгавартай байх, биеэ хэрхэн зөв авч явах зэргийг хоригдлуудад заадаг байх ёстой хэмээн үзэж байжээ. Хоёр дахь үзлийг дэмжигсэд шоронг ёсзүйн сургалт авах боломжтой хүний амьдрах боломжтой байгууламж байх ёстой бөгөөд ингэснээр хоригдлуудын зан төлөв "засагдаж" суллагдсаныхаа дараа нийгэмд үлгэр жишээ гишүүд болох болно гэдэгт итгэдэг.

Шоронгийн шинэчлэлийн дараагийн асуудал нь Жереми Бентамтай холбогдох бөгөөд түүний санаачилсан дугуй хэлбэртэй шорон нь хяналтын болон олон нийтийн хяналтын олон зарчмуудыг нэвтрүүлсэн бөгөөд эдгээр нь орчин үеийн шоронгийн загварын суурь болж өгсөн. Дугуй хэлбэртэй загварт хоригдлууд дугуй хэлбэртэй, ажиглалтын цамхаг руу харуулан байрлуулсан торонд нэг нэгээрээ байх ба хуягууд ажиглалтын цамхагаас

торнуудыг харах боломжтой харин хоригдлууд хуягуудыг харах боломжгүй байх зохион байгуулалттайгаар бүтээгджээ. (Архетиктор нь 1791 оны Вилли Ревелигийн загвар).

Мөн шоронгийн шинэчлэлд Жонн Ховард⁷⁵ нэлээд хувь нэмэр оруулсан билээ. Тэрээр Бэдфордайерын өндөр хэргэмт цагдаа байхдаа Англи болон Европын олон шоронгоор яван судалгаа хийж, 1777 онд "Шоронгийн нөхцөл байдал" нэртэй өгүүлэл гаргасан байна. Түүний хамгийн сэтгэл зовоосон зүйл нь хоригдлууд ял шийтгэлээ дуусгасан ч шоронгийн төлбөрийг барагдуулж чадаагүйгээс хоригдсоор байгааг олж мэдсэн явдал байв. Иймд тэрээр хоригдлуудыг тус тусад нь хорих, шоронгийн ажилтнууд мэргэжлийн бөгөөд төрөөс цалинждаг байх, хориход гадны хяналт бий болгох болон хоригдлуудад амьдрах боломжтой нөхцөл, эрүүл хоол хүнсээр хангах шаардлага зэрэг маш өргөн хүрээг хамарсан системийн шинэчлэлийн асуудлуудыг санал болгосон юм. Түүний дурсгалд зориулан "Хорих Шинэчлэлийн Говард Лиг" нэртэй шоронгийн шинэчлэлийн буяны үйл ажиллагаа байгуулагдсан билээ.

Ховардын энэхүү судалгаа, өгүүлэл дээр тулгуурлан 1779, онд "Хорих ангийн тухай хууль" батлагдан гарсан бөгөөд энэ хуулиар тусгаарлан хорих, шашины хичээл, ажлын дэглэм, эрэгтэйчүүдийн эмэгтэйчүүдийн гэх төрийн хоёр хорих газрын тухай зааж өгсөн боловч зөвлөлийн гишүүдийн хоорондын маргаан, Францтай хийсэн

⁷⁴ Христийн шашин (christianity) Есүс-ийн сургаалд үндэслэн МЭ I зуунд үүсэн шашин. Britannica Ширээний нэвтэрхий толь. NEPKO, 3680-р талд, ISBN 978-99962-66-20-10

⁷⁵ John Howard (1726.09.02 – 1790.01.20) Английн анхны шоронгийн шинэчлэгч, буянтан

дайны дарамт шахалт зэргээс шалтгаалан эдгээр хорихуудыг байгуулалгүй, шоронгууд орон нутгийн мэдэлд хэвээр байсаар байв. Гэвч нэг их удалгүй эрх мэдэл бүхий шүүгчид томилогдон санал болгосон өөрчлөлтүүдийн ихэнхийг хэрэгжүүлж, 1815 онд шоронгийн төлбөрийг үгүй болгосон юм.

Тухайн үед босогчид шоронгийн нөхцөл байдлын тухай олон нийтэд дэлгэх, компанит ажил явуулах явдал их байсан юм. Элизабет Фрай⁷⁶ нь тухайн үед Ньюгэйт шоронгийн нөхцөл байдал, эмэгтэйчүүдийн хэсэгт нь эмэгтэйчүүд хүүхдүүдийн тоо хэтэрхий их байгаа тухай, тэдгээрийн зарим нь шүүх хурлаар ч ороогүй байгаа тухай баримтжуулжээ. Тэнд байгаа хоригдлууд жижиг камертаа өөрсдөө хоолоо хийн, хувцсаа угааж, сүрлэнд дээр унтдаг тухай нийтэлсэн юм. 1816 онд тэрээр эцэг эхтэйгээ хоригдож буй хүүхдүүдэд зориулан шоронгийн сургууль бариулж чадсан бөгөөд хяналтын системийг бий болгож, эмэгтэйчүүдийг юм оёулах, Библи уншуулахыг шаардсан ба 1817 онд Ньюгэйтэд хоригдож буй эмэгтэй хоригдлуудын шинэчлэлийн холбоог байгуулахад дэмжлэг үзүүлсэн билээ.

Орчин үеийн шоронгийн системийн онол нь анх Жереми Бентам⁷⁷-ын энэрэнгүй үзлийн нөлөөгөөр Лондонд үүссэн бөгөөд Бентамын дугуй хэлбэртэй шорон нь анхны ажиглалт, хяналтын системийг нэвтрүүлж, орчин үеийн шоронгийн

хяналтын суурь болжээ. Шүүх хурал хүртэл хоригдох хугацаа нь ял шийтгэлийн нэг хэсэг болох болгосон явдал тухайн үедээ шинэчлэл байсан билээ. Түүний үзэл нь гэмт хэрэгтнийг засан хүмүүжүүлэх төв болгон ашиглах шоронгуудыг бий болгоход нөлөөлсөн юм. Олон төрлийн бага хэрэгт ял шийтгэлийн дээд хэмжээ өгөхөөс татгалзаж, хорих ял оноох, засан хүмүүжүүлэх нь шинэчлэлийг баримтлагчид, улс төрчдийн талархлыг хүлээжээ.

XIX зууны эхэн хагаст өмнө нь цаазын ял өгдөг байсан олон гэмт хэрэгт цаазын ял буюу ялын дээд хэмжээ өгөх нь тохиромжгүй хэмээн үзэх болж, XIX зууны дунд үед аллагаас бусад ихэнх ноцтой хэргүүдэд цаазын ялыг хорих ялаар орлуулах болсон байна.

Миллбанк⁷⁸ шорон нь Англи улсын анхны шорон бөгөөд 1816 онд 1000 хүрэхгүй хоригдол авах хүчин чадалтай байгуулагджээ. 1824 он гэхэд 54 шорон сахилга батын системийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 1840-өөд он гэхэд Австрали руу хорих тээврийг болон хорих усан завиудыг хоригложээ.

Харин Их Британий Жошуа Жебб⁷⁹ нь нэг жилд нэг том шорон барих том төлөвлөгөө гаргасанаар Лондонд 1842 онд Пентонвиллын шорон нээгдсэн нь гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн гол хэлбэр нь хорих арга болж, хорих ял оногдуулалтын хувь өсөх чиг хандлагын эхлэл болжээ.

⁷⁶ Elizabeth Fry (1780.05.21 – 1845.10.12), Английн шоронгийн шинэчлэгч, нийгмийн шинэчлэгч, христэд итгэгч нийгэлсэнгүй үзэлтэн

⁷⁷ Jeremy Bentham (1748.02.18 – 1832.06.06) Их Британийн хуульч, философич ба нийгмийн шинэчлэгч

⁷⁸ О.Батсайхан, С.Баасандорж. Хорих байгууллагын архитекторын хөгжлийн зарим асуудал.УБ., 2013. 72-84 талд ISBN 978-99929-71-65-9

⁷⁹ Joshua Jebb (1793.05.08 – 1863.06.23) Хааны инженер бөгөөд Их Британий хорих ялтануудын талаарх ерөнхий судлаач